



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/100

Бат-Өлзий сум

Ажлын гүйцэтгэлийг хүлээн авах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.8, 9.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн Малын чанар сайжруулахад зориулагдсан малыг ялган ангилах тоног төхөөрөмж хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)

Гишүүд: Э.Бадамханд (Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршоо хариуцсан мэргэжилтэн)

Э.Буянтогтох (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

П.Содномбалжир (Малын их эмч)

Б.Пүрэвсүрэн (Гэрээт нягтлан бодогч)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолт, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдлыг хянан үзэж, гэрээний шаардлагыг биелүүлсэн нөхцөлд акт үйлдэн хүлээн авахыг ажлын хэсэг (Н.Орхонтуул), хөрөнгийг байгууллагын өмчийн бүртгэлд бүртгэхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Малыг ялган ангилах тоног төхөөрөмжийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (Э.Дашдулам)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

